Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд болон Сангийн сайдын холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эдийн засаг, хөгжлийн яам 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/113 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,820,757.3 мянган төгрөгөөр буюу 3.7 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	98,000.0	98,000.0
Авлага	517,499.9	8,731.2	(508,768.7)
Бараа материал	512,328.7	564,371.9	52,043.2
Бусад эргэлтийн хөрөнгө	19,200.0	5,595,179.3	5,575,979.3
Үндсэн хөрөнгө	1,445,158.9	2,541,587.3	1,096,428.4
Нийт хөрөнгө	2,494,187.5	8,807,869.7	6,313,682.2
Өр төлбөр	39,987.6	1.0	(39,986.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,454,199.9	8,807,868.7	6,353,668.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,494,187.5	8,807,869.7	6,313,682.2

Дансны үлдэгдэлд дараах материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны 98,000.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь тайлант онд шинээр байгуулсан ахмадын сангийн мөнгөн хөрөнгө байна.
- Авлага дансны үлдэгдэлд дотоод томилолттой холбоотой авлага 8,731.2 мянган төгрөг байна.
- Бараа материалын дансны үлдэгдэлд 564,371.9 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 77,782.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 116,469.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 10,864.7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн материал, 29,570.2 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, нийт 234,686.5 мянган төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, нийт 182,643.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан,
- Бусад эргэлтийн хөрөнгө данс тайлант онд 5,595,179.3 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 11 дүгээр байрны засварын ажлын зардал 5,575,979.3 мянган төгрөгийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд хуримтлуулан бүртгэснээс шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгийн дансны 2,541,587.3 мянган төгрөгийн үлдэгдэлд шинээр бэлтгэсэн 1,326,273.5 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 151 дүгээр тогтоолоор Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслөөс 286,190.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс 87,313.5 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг балансаас баланст шилжүүлэн авсантай холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 6,353,668.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 11,280,806.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс материаллаг өөрчлөлт гарсан зардлын үзүүлэлтийг дурдвал цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 630,406.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 97,500.0 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 457,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 1,496,513.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг зардлыг 18,406.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 33,800.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 24,137.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,010,641.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Тус байгууллагын 2023 оны төсвийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 12,912,053.3 мянган төгрөгөөр тооцон баталсан бөгөөд тайлант оны батлагдсан төсвийг 44,492.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Үүнд

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 78,250.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 37,581.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 269,195.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 56,182.9 мянган төгрөг, урсгал шилжүүлэг зардлыг 12,500.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 173,757.4 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 45,345.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 190,113.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 12,956,545.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээс гүйцэтгэлээр 12,956,545.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 12,650,686.1 мянган төгрөгийг зарцуулж, 295,009.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,650,686.1 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 25,459.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1,754.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 4,981.4 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 3,646.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 237,816.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 679.5 мянган төгрөг, засгийн газрын урсгал шилжүүлэг зардлыг 31,515.5 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 6.9 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70201	Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	12,956,545.9	12,650,686.1	305,859.8	97.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	12,242,088.5	11,968,251.3	273,837.2	97.8
1.2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	78,310.0	78,310.0	-	100.0

**Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	446,418.3	446,418.3	-	100.0
1.4	80239	Тээврийн үйлчилгээ	72,840.0	72,339.8	500.2	99.3
1.5	80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	31,515.5	-	31,515.5	-
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	50,510.8	50,503.9	6.9	100.0
1.7	81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	34,862.8	34,862.8	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус яам нь тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан 140,817.5 мянган төгрөгийн хандив, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 565,000.0 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчаас 980,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг тус тус бүрдүүлсэн байна. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 1,636,625.8 мянган төгрөгийг зарцуулж, 35,975.2 мянган төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын А/53, нэмэлт А/73 тушаалаар тус яамны 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 7,110,020.5 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 409,832.9 мянган төгрөг, нийт 7,519,853.4 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 7,444,361.2 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдаж авснаас нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 6,667,547.8 мянган төгрөгийн засварын ажил, харьцуулалтын аргаар 409,832.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ерөнхий гэрээний журмаар 55,902.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, шууд худалдан авалтаар 311,078.5 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан бэлтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх, ажил гүйлгээний утгыг товч тодорхой бичих, дотоод аудитад ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийх, ажлын төлөвлөгөө дээр тусгаж ажиллах, барилга байгууламжийн урсгал засвар, их засварын ажлын зардлыг төсвийн төсөлд тусгаж, батлуулахгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор О.Наранбат, ахлах аудитор Э.Энхбаатар нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/197 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,212,537.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 78,188.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 8,118,820.9 мянган төгрөг болж, 2022 оноос 64.2 хувиар өссөн нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

Материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 8,118,820.9 мянган төгрөгөөс 1.5 хувир буюу 121,782.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус яам цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг "Ерөнхий гэрээ" байгуулан худалдан авсан бөгөөд тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 55,902.0 мянган төгрөгийн Business Standard буюу Onedrive эрхийг цахим дэлгүүрээс худалдаж авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 16 төрлийн 146 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Байгууллагын худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаж, батлаагүй тавилга, тоног төхөөрөмжийг бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтаан жижиглэж, нийт 62,158.0 мянган төгрөгийн шууд худалдан авалтыг хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоолоор баталсан "Босго үнэ шинэчлэн батлах тухай" хавсралтын 2-т "Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг", 4-т "Цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар 20.0 сая төгрөг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй, үндсэн хөрөнгө худалдан авахдаа нэр төрөл, ижил төстэй байдлаар нь багц үүсгэж тендер шалгаруулалт зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бөгөөд ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад шалгадагч байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгадагч байгууллагад танилцуулж, зөрчлийг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн зөрчлийг арилгах 97,914.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага, алдааг засах 4 зөвлөмж өгснийг 75.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	97,914.5	3	97,914.5	100.0
Зөвлөмж	4	-	3	-	75.0
Нийт дүн	7	97,914.5	6	97,914.5	85.7

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, анхан шатны баримттай холбоотой асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2023 оны А/211 дүгээр тушаалаар баталсан “Ангилал шинэчлэн батлах” тухай тушаалын хавсралтууд болон А/229 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг хэрэгжүүлж ажилласан эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,673,979.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 5,673,979.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Тайлант онд ЗГ-ын 11 дүгээр байрны дотоод өөрчлөлт, сайжруулалт засварын ажил, цэвэр бохир усны шугам, кондиционерийн систем зэрэг засварын зардалд 5,575,979.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, их засварын ажлыг гүйцэтгүүлсэн боловч барилгын өртөгт шингээн капиталжуулаагүй, хөрөнгийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлгүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан;
- Тайлант оны цалингийн сангийн 3 хүртэлх хувиар байгуулсан ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн байдлын тайланд дутуу илэрхийлсэн.

Аудитаар нийт 58,580.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 52,810.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 6,039.4 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 58,850.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 62,932.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

1. Бараа, ажил үйлчилгээний нэхэмжлэхийг бөөн дүнгээр хүлээн авсан, худалдагч байгууллагаас зарлагын баримт хүлээн аваагүй, ямар ажил үйлчилгээ, бараа материал худалдан авсан нь тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 52,810.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээгээр гүйцэтгэж буй ажлын гэрээг дүгнээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан зөрчлийг арилгаж, албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Урсгал зардал холбоотой асуудал

Илрүүлэлт: Өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтгүй, барилга байгууламжийн урсгал засвар, их засварын ажлын зардлыг төсвийн төсөлд тусгаж, батлуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.2-т "холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтгүй, барилга байгууламжийн урсгал засвар, их засварын ажлын зардлыг төсвийн төсөлд тусгаж, батлуулахгүй байх.

2. Мөнгөн хөрөнгө холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажил гүйлгээний утгыг тодорхойгүй бичсэн, тухайлбал "Барааны үнэ" гэсэн гүйлгээний утгатай нийт 6,039.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу "монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр гүйлгээний утга бүртгэлд тусгаж хэвших.

3. Дотоод аудит холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод аудитад ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийх талаар ажлын төлөвлөгөө дээр тусгаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-т "дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод аудитад ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага, этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийх, ажлын төлөвлөгөө дээр тусгаж ажиллах.

4. Төрийн хэмнэлтийн тухай хуультай асуудал

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуульд Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэл бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэхээр тусгасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, автотээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх.

5. Эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эдийн засгийн зардлын ангилал зөрүүлэн дараах ажил гүйлгээг гаргасан байна. Үүнд: Зардлын ангилал 210801 ангиллаас 33,181.3 мянган төгрөгийн албан томилолтын

зардал, 363,911.3 мянган төгрөгийн байр ашиглалтын зардал, 210901 ангиллаас 5,058.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зардал, 21090101 ангиллаас 1,466.4 мянган төгрөгийн автомашин сэлбэгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын эдийн засгийн ангилал зөрчин зарцуулалт гаргасан зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд ЗГ-ын 11 дүгээр байрны дотоод өөрчлөлт, сайжруулалт засварын ажил, цэвэр бохир усны шугам, кондиционерийн систем зэрэг засварын зардалд 5,575,979.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, их засварын ажлыг гүйцэтгүүлсэн боловч барилгын өртөгт шингээн капиталуулаагүй, хөрөнгийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлгүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан:	1	5,575,979.3	1	5,575,979.3			1	5,575,979.3				
Тайлант оны цалингийн сангийн 3 хүртэлх хувиар байгуулсан ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн санхүүгийн тайланд тусгаагүй.	1	98,000.0	1	98,000.0			1	98,000.0				
Дүн	2	5,673,979.3	2	5,673,979.3			2	5,673,979.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлгүй, барилга байгууламжийн урсгал засвар, их засварын ажлын зардлыг төсвийн төсөлд тусгаж, батлуулсан байна.	1	-						1	-			
Ажил гүйлгээний утгыг тодорхойгүй бичсэн, тухайлбал "Барааны үнэ" гэсэн гүйлгээний утгатай нийт 6,039.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт гаргасан байна.	1	6,039.4						1	6,039.4			
Дотоод аудитад ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийх талаар ажлын төлөвлөгөө дээр тусгаж ажиллаагүй байна.	1	-						1	-			



